

“Монгол улсын эдийн засгийг сэргээн хөгжүүлэх нөөц боломжийн тухайд”, Нарангийн “Хоёр улсын эдийн засаг худалдааны харилцаа”, Баатарын “Монгол-Хятадын хамтын ажиллагааны урьд, одоо, ирээдүй”, Насангийн “Зүүн хойт Азийн бус нутгийн эдийн засгийн хамтын ажиллагаанд Монгол улсын эзлэх байр суурь, үзүүлэх нөлөө” зэрэг сонирхолтой өгүүллүүд оржээ. Хятадын эрдэмтэн судлаачдын өгүүллүүд нь гаднын хүний нүдээр бидний байгаа байдал, нөөц боломжийг харуулсан нь сонирхууштай, санаа авууштай зүйлс олонтаа харагдана. Энэ өчүүхэн танилцуулгад тэр бүрийг нэг нэгэнгүй харуулах боломжгүй тул уншигчдад шинэ номын мэдээлэл хүргэх үүднээс уг хамтын бүтээлд орсон өгүүлүүдээс түүвэрлэн цөөн хэдийг л дурьдсан болохыг болгооно бизээ.

Эцэст тэмдэглээд энэхүү хамтын бүтээл хоёр орны харилцааны асуудлыг сонирхон судалдаг, сэхээтэн мэрэгжилтэн, бодлого боловсруулагчид, гадаад харилцааны чиглэлийн багш, оюутнуудын сонирхон уншихуйц бүтээл болжээ.

М.ХУРМЕТХАН

**“МОНГОЛ УЛС, АМЕРИКИЙН НЭГДСЭН УЛСЫН
ХАРИЛЦАА, ХАМТЫН АЖИЛЛАГАА” (1945-1991)**

ШУА-ийн Олон улс судлалын хүрээлэнгийн хувьд өнгөрсөн зууны сүүлчийн он эрдмийн бүтээлийн ургац арвинтай жил боллоо. Тус хүрээлэнгийн эрдэмтэдээс олон улсын болон монголын гадаад харилцаа, хамтын ажиллагаа, орон судлалын чиглэлээр хэд хэдэн бүтээл хэвлүүлэв. Түүний нэг нь Төв, Дундад Ази, ялангуяа Афган, Казакын судлалаар мэрэгшсэн эрдэмтэн Мухамед Хурметханы “ХХ зууны сэргэн мандлын гадаад харилцаа” төслийн хүрээнд хийж гүйцэтгэсэн “Монгол улс, Америкийн Нэгдсэн улсын харилцаа, хамтын ажиллагаа” (1945-1999) хэмээх бүтээл юм. Академич Н.Ишжамц агсан 1999 онд туурвиж хэвлүүлсэн “АНУ-аас Монголын хувьд явуулсан бодлого, Монгол-Америкийн харилцаа (1900-1987) номын шууд үргэлжлэл болох энэхүү ном оршил, 3 бүлэг, дүгнэлтийн хэсгээс бүрдэл болно. Зохиогчийн “Монгол улс, АНУ-ын харилцааны түүхээс XIX зууны эцсээс 1921 он хүртэл”, “БНМАУ, АНУ-ын харилцааны байдал” хэмээх эхний хоёр бүлэг нь зарим талаар академич Н.Ишжамц агсаны бүтээлтэй утга агуулга, ашигласан материалын хувьд давхцаж байгаа ч гэсэн зарим онцлог нэмэлт материал ашиглаж утга санааг баяжуулан тодруулснаараа зохих ач холбогдолтой, үнэ цэнэтэй болсон гэх үндэстэй байна. Энэ дашрамд дурьдахад АНУ, Монгол улстай дипломат харилцаа тогтооход олон талын хүчин зүйл нөлөөлсөн нь

мэдээж. Энд ардын дипломат бодлого ч зохих нөлөө үзүүлсэн. Тухайлбал Америкийн профессор, Монгол угсаатан Хангин Гомбожав, Джаб Номинов-Бурхинов нар Монгол улсын талаар төр засагтай зөв ойлголт өгөх талаар ихээхэн хүчин чармайлт гаргаж чухал үүрэг гүйцэтгэснийг Америкийн эрдэмтэд цохон тэмдэглэсэн байдаг. Номын “Монгол улс, АНУ дипломат харилцаа тогтоосны дараах үе” хэмээх 3-р бүлэгт зохиогч Монгол, Америкийн өнөөгийн харилцааны олон талт асуудлыг АНУ-ын 60 тоот тогтоол болон монголын талаар АНУ-ын баримтлах байр суурийг тусгасан бусад холбогдох баримт бичгийг өргөнөөр ашиглан нэлээд тодорхой харуулжээ. Зохиогч Монгол, Америкийн харилцаа хамтын ажиллагааны сүүлийн 10 гаруй жилийн түүхийг хураангуйлан авч үзэхдээ эдийн засаг, боловсрол соёл, шинжлэх ухаан, соёл урлаг, эрүүлийг хамгаалах, батлан хамгаалах зэрэг нийгэм-эдийн засгийн амьдралын олон салбарт хэрхэн өрнөн, амжилттай хөгжиж байгааг хоёр талын харилцааны эрх зүйн баримт бичиг, бусад тоо баримтад тулгуурлан дэлгэрэнгүй тусгасан нь нэн сайшаалтай. Зохиогч АНУ-аас Монголд үзүүлж буй эдийн засаг, техникийн тусламжийн талаар нэлээд арвин материал ашиглаж тодорхой өгүүлсэн боловч АНУ-ын санхүү, эдийн засгийн тусламж дэмжлэг түүнийг монголчууд хэрхэн үр ашигтай ашиглаж байгаа зэргийг нэлээд тогтож судалсан бол бүүр ч их ач холбогдолтой байх байсан болов уу гэсэн бодол төрсөн. Энэ мэтийг зохиогч цаашдын судалгаандаа анхааран үзэх нь дамжиггүй. Эрдэмтэн, судлаач М.Хурметхан зохиолынхоо төгсгөлийн хэсэгт АНУ дахь монгол судлал, Монгол дахь АНУ судлал, Монгол-Америкийн эрдэм шинжилгээний хамтын ажиллагааны тоймыг хураангуйлан авч үзсэн байна. М.Хурметханы бичсэн энэ бүтээлийг бүхэлд нь авч үзвэл Монгол улс, АНУ-ын харилцааны үе шат, өрнөл хөгжил, онцлогийг хоёр улсын харилцааны түүхэн баримтад тулгуурлан нэгтгэн дүгнэх оролдлого хийснээрээ чухал ач холбогдолтой бүтээл болсон гэж үзлээ. Нөгөө талаар Монгол улсын гадаад харилцааны түүх судлаачид, практик ажилтан нар болон их дээд сургуулийн багш оюутнуудын чухал гарын авлага болох нь дамжиггүй.